



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020.10.
2020.10.



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС

			Үүнээс	Үүнээс
			Эм	Эр
Баянхонгор	Баацагаан сум	1 058	198	860
Баянхонгор	Баянбулаг сум	494	83	411
Баянхонгор	Баянговь сум	887	210	677
Баянхонгор	Баянлиг сум	1 075	211	864
Баянхонгор	Баян-Овоо сум	853	190	663
Баянхонгор	Баян-Өндөр сум	744	146	598
Баянхонгор	Баянхонгор сум	9 633	3 417	6 216
Баянхонгор	Баянцагаан сум	1 036	218	818
Баянхонгор	Богд сум	900	187	713
Баянхонгор	Бөмбөгөр сум	1 015	210	805
Баянхонгор	Бууцагаан сум	1 090	230	860
Баянхонгор	Галуут сум	1 253	238	1 015
Баянхонгор	Гурванбулаг сум	653	100	553
Баянхонгор	Жаргалант сум	905	209	696
Баянхонгор	Жинст сум	644	115	529
Баянхонгор	Заг сум	633	123	510
Баянхонгор	Өлзийт сум	1 147	250	897
Баянхонгор	Хүрээмарал сум	528	86	442
Баянхонгор	Шинэжинст сум	768	170	598
Баянхонгор	Эрдэнэцогт сум	1 297	271	1 026
Нийт		26 613	6 862	19 751

ХҮН АМЫН ТОО

Засаг захиргааны нэгж	2019			2018		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Баянхонгор	89,253	43,974	45,279	88,359	43,530	44,829
Баянхонгор	32,297	15,399	16,898	31,685	15,127	16,558
Баацагаан	3,282	1,673	1,609	3,307	1,679	1,628
Баянбулаг	1,789	878	911	1,767	877	890
Баянговь	2,986	1,438	1,548	2,922	1,420	1,502
Баянлиг	3,860	1,906	1,954	3,848	1,906	1,942
Баян-Овоо	2,594	1,353	1,241	2,650	1,384	1,266
Баян-Өндөр	2,650	1,342	1,308	2,668	1,350	1,318
Баянцагаан	3,592	1,809	1,783	3,590	1,811	1,779
Богд	3,127	1,541	1,586	3,113	1,516	1,597
Бөмбөгөр	3,323	1,675	1,648	3,288	1,644	1,644
Бууцагаан	3,703	1,858	1,845	3,670	1,836	1,834
Галуут	4,112	2,138	1,974	4,103	2,122	1,981
Гурванбулаг	2,273	1,128	1,145	2,216	1,096	1,120
Жаргалант	2,901	1,443	1,458	2,961	1,474	1,487
Жинст	2,228	1,104	1,124	2,192	1,084	1,108
Заг	2,086	1,064	1,022	2,073	1,050	1,023
Өлзийт	3,845	1,926	1,919	3,870	1,945	1,925
Хүрээмарал	1,793	908	885	1,748	883	865
Шинэжинст	2,493	1,230	1,263	2,449	1,205	1,244
Эрдэнэцогт	4,319	2,161	2,158	4,239	2,121	2,118



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2020 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 12946.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 434.4 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна. 2020 оны 10 сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Богд, Хүрээмарал, Шинэжинст, Баян-Өндөр, Бууцагаан, Баянговь, Гурванбулаг, Жаргалант, Бөмбөгөр, Галуут, Эрдэнэцогт, БаянОвоо, сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл газрын төлбөр 12.4 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 202.1 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 222.8 сая төгрөг, НӨАТатвар 44.9 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 0.9 сая төгрөг, хог хаягдлын хураамж 2.5 сая төгрөгөөр тус тус тасарч, ЦХТА орлого /суутган-1/ 412.8 сая төгрөг, ус ашигласны төлбөр 176.6 сая төгрөг, ИОТТХ 57.1 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 41.8 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 17.4 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ. Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2.6 хувь, нэмүү өртгийн албан татвар 7.5 хувь, ЦХТА орлого 39.4 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 4.2 хувь, хүү торгууль 9.6 хувь. бусад төлбөр хураамж 15.7 хувийг тус тус эзэлж байна



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 09 дүгээр сарын 31-ны байдлаар арилжааны банкуудаар нийт зээлийн үлдэгдэл 201072.2 сая төгрөг байгаагийн 3104.8 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2971.4 сая нь чанаргүй зээл байна.

2020 оны эхний 9 сарын байдлаар нийт хадгаламжийн үлдэгдэл 143886.4 сая төгрөг болжээ. Үүний 41516.8 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 102286.0 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

№	ХӨРӨНГӨ	2020-10-05
1	Мөнгөн хөрөнгө	2,357,486.3
2	Зээлийн өрийн үлдэгдэл / цэвэр/	201,072,236.0
	Хэвийн зээл	196,457,873.4
	Хугацаа хэтэрсэн зээл	3,104,789.9
	Чанаргүй зээл	2,971,357.3
	Хэвийн бус зээл	1,058,625.3
	Эргэлзээтэй зээл	722,177.8
	Муу зээл	1,190,554.2
	/ЗТУБАХСАН/	-
	Нийт зээл	1,461,784.6
		202,534,020.6
3	Бусад хөрөнгө	8,110,443.1
4	Үндсэн хөрөнгө / цэвэр /	4,703,537.6
5	Харилцах данс	24,088,823.0
6	Хадгаламж	143,886,374.8
	Хугацаагүй хадгаламж	41,516,756.8
	Хугацаатай хадгаламж	102,286,044.8
	Бусад хадгаламж, сертификат	83,573.1
7	Бусад өр төлбөр	31,395,105.4
8	Ашиг/Алдагдал	15,575,815.6



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 10 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 0.1 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд голлож хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас бөс бараа, орон сууц, орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ. тээвэр бүлгийн бараа бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.5 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, хувцас бөс бараа, орон сууц, орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ бүлгийн бараа бүтээгдэхүүний бүлгийн барааний үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 10 дугаар сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 2.8 хувиар өссөн байгаа нь голлож хувцас, бөс бараа, гутал, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Барааны бүлгээр	2020.10	2020.10	2020.10
	2019.10	2019.12	2020.09
ЕРӨНХИЙ ИНДЕКС	102.8	102.5	100.1
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	103.9	104.4	99.1
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	101.5	100.6	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	108.3	106.8	101.1
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД	99.8	99.8	100.6
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	105.3	105.0	100.3
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.5	102.5	99.9
ТЭЭВЭР	93.5	93.1	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.2	100.2	100.0
АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	102.9	102.9	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЗОЧИД БУУДАЛ НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	108.6	108.6	100.0
БУСАД БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	104.7	104.7	100.9



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал тооллогын дүнгээр 2019 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн тоо 4644.8 мянга болж, 2018 оныхоос 9.3 хувь буюу 395.3 мянган толгойгоор өссөн байна. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо 189.5 мянга, үхэр сүрэг 257.6 мянга, тэмээн сүрэг 58.1 мянга, хонь 1406.0 мянга, ямаа 2733.7 мянган толгой болж нийт мал сүргийн тоо таван төрөл дээрээ өсчээ.

Нийт мал сүргийн дотор адуу 4.1 хувь, үхэр 5.5 хувь, тэмээ 1.3 хувь, хонь 30.3 хувь, ямаа 58.8 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 0.5 пунктээр өсч, хониных 0.3 пункт, үхэр 0.1 пункт, тэмээнийх 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Малын тоо 2019 онд

МЯН.ТОЛ

	Малын тоо		2019/2018		Нийт дүнд эзлэх хувь	
	2018	2019	Зөрүү	Хувь	2018	2019
Бүгд	4249.5	4644.8	395.3	109.3	100.0	100.0
Адуу	175.9	189.5	13.6	107.7	4.1	4.1
Үхэр	239.8	257.6	17.8	107.4	5.6	5.5
Тэмээ	57.4	58.1	0.7	101.2	1.4	1.3
Хонь	1297.5	1406.0	108.5	108.4	30.6	30.3
Ямаа	2478.9	2733.7	254.8	110.3	58.3	58.8

Манай аймаг улсад нийт малын тоогоор 4644.8 мянган толгой малтай зургаад, ямааны тоогоор 2733.7 мянган толгой ямаатай нэгдүгээрт, тэмээний тоогоор 58.1 мянган толгой тэмээтэй хоёрдугаарт, үхрээр 257.5 мянган толгой үхэртэй есдүгээрт, адуугаар 189.5 мянган толгой адуутай аравт, хониор 1406.0 мянган толгой хоньтой арваннэгдүгээрт орж байна.

Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 сумд Баацагаан 368.3 мянган толгой, Галуут 309.6 мянган толгой, Бууцагаан 303.1 мянган толгой, Бөмбөгөр 299.6 мянган толгой, Өлзийт 277.5 мянган толгой мал тус тус тоолуулжээ.

Аймгийн хэмжээнд 9 дүгээр сарын мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээр оны эхний хээлтэгчийн 77.2 хувь буюу нийт 1521784 хээлтэгч мал төллөсөн ба гарсан төлийн 96.9 хувь буюу 1466826 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 9412, унага 38080, тугал 65626, хурга 495789, ишиг 857919 толгой тус тус бойжсон байна.

2020 оны 9 дүгээр сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 55097 толгой мал хорогдсон нь оны эхний малын 1.2 хувийг эзлэж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 130, адуу 4268, үхэр 2936, хонь 17704, ямаа 30059 толгой тус тус хорогджээ, мөн нийт хорогдсон малын 32.9 хувь буюу 18120 толгой хээлтэгч мал хорогдсон байна, төрлөөр нь харвал ингэ 24, гүү 1501, үнээ 890, эм хонь 5976, эм ямаа 9729 толгой хорогджээ.

Тариалсан талбайн 2020 оны 06 сарын мэдээгээр нийт 555.5 га д тариалалт хийсэн байна. Тариалсан талбайг төрлөөр нь задлаж харвал төмс 204.6 га-д, тэжээлийн ургамал 236.8 га-д, хүнсний ногоо 109.8 га-д тус тус тариалжээ.

Тариалсан талбайг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 33.5 га буюу 19.6 хувиар өссөн, тэжээлийн ургамал 56.1 га буюу 19.2 хувиар, хүнсний ногоо 15.9 га буюу 14.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 30-ний байдлаар 1818.7 тонн төмс, 717.6 тонн хүнсний ногоо хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс 155.6 тонн (9.3 %)-оор өсч, хүнсний ногоо 81.3 тонн (11.3 %)-оор буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

2020 оны 10 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 33958.0 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5273.0 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна, ингэж өсөхөд нөлөөлсөн гол шалтгаан нь алт олборлолт, борлуулалт өссөнтэй холбоотой юм

Аж үйлдвэрийн борлуулалтын 2020 оны эхний 10 сарын гүйцэтгэл

Нийт борлуулалт товчоо, салбараар

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт (мян.төг)				
	2019		2020		<u>2020 2019</u>
	X	I-X	X*	I-X*	I-X*
Нийт дүн	5662825	28685017	4966931.1	33958104	118.4
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	4785082	23276298	3718950.2	26750589	114.9
Боловсруулах аж үйлдвэр	63005	699882.8	101277	1272584.1	181.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	635118.3	3357708.8	915140	4492653.5	133.8

Аж үйлдвэрийн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2020 оны эхний 10 сарын гүйцэтгэл

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Биет хэмжээ				<u>2020 2019</u>
		2019		2020		-
		X	I-X	X*	I-X*	I-X*
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Чулуун нүүрс	мян.тн	7.4	22.6	10.9	30.92	136.8
Алт	кг	39.8	215.6	26.086	214.536	99.5
Боловсруулах аж үйлдвэр						
Дулааны эрчим хүч	мян.Гкал	51.935	275.755	70.1	343.36	124.5
Хиам	тн	0.8	8	0.52	5.89	73.6
Боловсруулсан шингэн сүү	мян.л	0.275	3.988	0.46	3.579	89.7
Нарийн боов	тн	9.98	120.489	16.275	141.462	117.4
Талх	тн	12.074	134.693	17.96	169.852	126.1
Түгээсэн цэвэр ус	мян.м3	57	501.3	93.3	555.99	110.9



НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

2020 оны эхний 10 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 33685.4 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 7684.9 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1809.2 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 940.4 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 69.9 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 1527.4 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 275.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 81.5 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 39.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 373.6 сая төгрөг тус тус олгожээ

Нийгмийн халамжийн сангаас эхний 10 сарын байдлаар нийт 1658.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгож үүнээс жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 2228 эхчүүдэд 39.2 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 7596 эхэд 988.3 сая төгрөг, алдар цолтой 26 ахмадад 43.9 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 3693 хүнд 598.5 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 826 хүнд 180.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

Эхний 10 сард аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 868 болж өмнөх сараас 307 иргэнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 482 буюу 55.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 79.7 хувь буюу 692 иргэн, 45 дээш насныхан 176 иргэн 20.3 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой иргэд 525 буюу 60.5 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой иргэд 100 буюу 11.5 хувь, дээд, магистр, докторын боловсролтой иргэд 243 буюу 27.9 хувийг тус тус эзлэж байна.

2020 оны эхний 10 сард нийт ажилгүйчүүдээс 834 иргэн үүнээс 432 эмэгтэй ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 552 иргэн буюу 66.2 хувь нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 426 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 52.1 хувь буюу 222 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 75, барилгын салбарт 15, Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 79, Худалдааны салбарт 59, санхүүгийн болон даатгалд 3, төрийн удирдлага болон албан журмын нийгмийн хамгаалалд 70, боловсролд 21, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 19, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагаа салбарт 15 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 10 сарын байдлаар 1050 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалд 168, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 34, Хөдөө аж ахуйн салбарт 197, Барилгын салбарт 125, Боловсролын салбарт 56, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 229, уул уурхай олборлолтын салбарт 46, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 37, боловсруулах үйлдвэрлэлд 75,

зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 13, бусад салбаруудад 0-9 ажлын байрны захиалга иржээ.



ЭРҮҮЛ МЭНД

2020 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 1706 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеээс 19 төрөлт буурсан байна. Нийт төрсөн эхийн 92.0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 8.0 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 10 сарын байдлаар 17 гарчээ.

10 сарын байдлаар нийт 1089 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 123.7 байгааг өнгөрсөн оны мөн үе (151.4) тэй харьцуулахад буурч, сүрьеэгийн 2 нас баралт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад БЗДХ-ын тохиолдлын тоо буурч, нийт халдварт өвчний 83.5 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 910 тохиолдлын 18.2 хувийг заг хүйтэн, 63.7 хувийг трихомониаз, 18.1 хувийг тэмбүүгийн өвчлөл эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад заг хүйтэний өвчлөл буурч, бусад халдварууд ижил түвшинд байна.

Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар нас баралтын 340 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеээс 77 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 21.2 хувь нь эмнэлэгт нас барснаас 33.3 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 13231 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 23.1 хувийг алсын, 7.9 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага болон нийт дуудлаганд эзлэх алсын дуудлага нэмэгдэж, осол гэмтлийн дуудлага буурсан байна.




ГЭМТ ХЭРЭГ

1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн талаар:

Тус цагдаагийн газар нь 2020 оны эхний 10 сард иргэд, аж ахуйн нэгжээс 4121 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаж шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 634 нэгжээр буюу 18.1 хувиар өссөн байна.

- ✓ 461 буюу 54 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
- ✓ 356 буюу 41.6 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан.




- ✓ 2335 буюу 71.4 хувийг Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн
- ✓ 861 буюу 26.3 хувийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзсан
- ✓ 37 буюу 1.1 Харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 276 оуюу 32.3 хувииг 5 хоногт, 529 буюу 61.9 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 3139 буюу 96 хувийг 5 хоногт, 95 буюу 2.9 хувийг 6 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

2. Бүртгэгдсэн гэмт хэрэг:


Аймгийн хэмжээнд энэ оны эхний 10 сард 411 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 145 нэгжээр буюу 26 хувиар буурсан.

Баянхонгор аймаг нь гэмт хэргийн гаралтаараа хил залгаа Өвөрхангай аймгаас 19.4 хувиар бага бол Архангай, Говь-Алтай, Завхан аймгаас 4,5-1,8 дахин их байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийн 183 буюу 44,5 хувь нь Баянхонгор суманд, 238 буюу 57,9 хувь нь бусад суманд үйлдэгдсэн ба Баянхонгор суманд үйдэгдсэн хэрэг 45,7 хувиар буурсан бол, бусад сумдад үйлдэгдсэн хэрэг 8,6 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 280 хэрэг бүртгэгдснээс 147 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 52,5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,3 пунктээр өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 318 буюу 77,3 хувь нь хөнгөн ангилалын, 93 буюу 22,6 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



2020 оны 10 сарын байдлаар /өссөн дүнгээр/



Хэргийн ангилал	2019 оны 10 сар	2020 оны 10 сар	Харьцуулалт	
Хүнийг алах	5	2	-3	-60%
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	5	3	-2	-40%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	164	120	-44	-26,8%
Хүчиндэх	18	18		
Хулгайлах	156	77	-79	-50,6%
Тээврийн хэрэгслийн хулгай	8	2	-6	-75%
Мал хулгайлах	67	65	-2	-2,9%
Дээрэм	1	2	1	100%
Залилах	24	23	-1	-4,1%
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг	1	1		

сонирхолын эсрэг				
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	22	23	1	4,5%
Хүрээлэн буй орчны эсрэг	21	44	23	1,1 дахин
Бусад				

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа:

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 411 гэмт хэргээс 108 буюу 26,2 хувь нь гэр орон сууцанд, 34 буюу 8,2 хувь нь гудамж талбайд, 34 буюу 8,2 хувь нь олон нийтийн газар, 6 буюу 1,4 хувь нь төрийн байгууллагад, 5 буюу 1,2 хувь нь төрийн бус байгууллагад, 19 буюу 4,6 хувь нь авто замд, 8 буюу 1,9 хувь нь аж ахуйн нэгжид, 197 буюу 47,9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 342 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 нэгжээр буюу 5 хувиар буурсан бөгөөд үүнээс 33 буюу 9,6 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 416 иргэн хохирч, үүнээс 145 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 17 нэгжээр буюу 10,5 хувиар, 11 хүн нас




барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11 нэгжээр буюу 50 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 1046,3 сая төгрөгийн хохирол учирснаас 436,7 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 41,7 хувьтай байна.

2. Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймагт 2020 оны эхний 10 сард 24845 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1164 нэгжээр буюу 4,9 хувиар өссөн. **Ердийн журмаар /бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр/ 22423 зөрчлийг 449816,8 мянган төгрөгөөр, 2422 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 385400,0 мянган төгрөгөөр тус тус торгож, нийт 835216.8 мянган төгрөгийн торгууль ногдуулан ажилласан байна.**

355 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй



харьцуулахад 50 нэгжээр буюу 16,3 хувиар өссөн, 528 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэгжээр буюу 2.5 хувиар буурсан байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
		Даваа гараг	3760 буюу 15.1 %
		Мягмар гараг	3926 буюу 15.8%
		Лхагва гараг	4088 буюу 16.4%
		Пүрэв гараг	3992 буюу 16,0%
		Баасан гараг	3542 буюу 14.2 %
		Бямба гараг	2870 буюу 11.5%

01-05 цагт	650 буюу 2,6%	Ням гараг	2667 буюу 10.7%
------------	---------------	-----------	-----------------

Энэ хугацаанд 849 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 182 нэгжээр буюу 17,6 хувиар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 28 буюу 3.3 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**